

# 9

## **КРЕДИТ БА ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН ТӨСӨВЛӨЛТ**

**Г.Билгээ**

Шинэ зууны Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг шийдвэрлэхэд боловсролын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэх, боловсролын тогтолцоог олон улсын нийтлэг жишиг, хөгжлийн хандлагад нийцүүлэн, зах зээлийн харилцаатай нягт уялдаатай шинэчлэх нийгмийн шаардлагын үүднээс хууль, эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар багагүй зүйлийг хийгээд байна.

Улс үндэстний хөгжлийн асуудалд зөвхөн эдийн засгийн үүднээс төдийгүй түүнийг олон талаас нь судалж иж бүрэн хандах, үйлдвэрлэгч-хэрэглэгч болон нийгмийн эрх ашгийн зааг дээр асуудлыг цогцоор авч үздэг макромаркетингийн үзэл баримтлалын үүднээс судлах нь орчин үеийн чиг хандлага болоод байна. Үүнд макро, микро түвшний удирдлагын харилцан уялдааг хангах нь нэн чухал гэж үздэг.<sup>4</sup>

ТБУС хуулийн хүрээнд хийгдэж байгаа шинэчлэл нь их өргөн хүрээтэй олон асуудлыг багтаасан төрийн захирагааны төдийгүй микро түвшинд санхүүгийн удирдлагыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэх үндэс нь болно. Боловсролын удирдлагын төвлөрлийг сааруулан, сургалтыг төлбөртэй болгож, төрийн бус өмчийн оролцоог бий болгосноор зах зээлийн нийгэмд амьдарч, ажиллах чадвартай мэргэжилтэн бэлдэх өрсөлдөөний орчин бий боллоо.

Манай орны төрийн өмчийн 11 их сургууль, түүний харьяа 18 дээд сургуульд нийт их дээд сургуульд суралцагчдын 70 орчим хувь, нийт их дээд сургуулийн 60-аад хувийг эзэлж байгаа төрийн өмчийн бус их, дээд сургуулиудад нийт суралцагчдын 30-аад хувь нь суралцаж байгаа нь салбарын бүтэц ихээхэн өөрчлөгдсөнийг харуулж байгаа бөгөөд хүн амын тоотой харьцуулахад хэт олширсон гэж үздэг. Эдгээргээс 37 хувь нь 100-600 орчим суралцагчидтай жижиг, 35.7 хувь нь 601-1500 орчим суралцагчидтай жижгэвтэр сургуулиуд, 8.1 хувь нь 6000-20000 орчим суралцагчидтай 6 томоохон сургуулиуд байгаад анхаарлаа хандуулах нь чухал. Учир нь их, дээд сургуулиуд жижиг байх нь төдийлөн зохистой хандлага биш бөгөөд

<sup>4</sup> Д.Дагвадорж, "Макромаркетинг ба төрийн удирдлага" илтгэл УБ, 2008

тэдгээрийн давуу болон сул талыг сайн харгалзаж оновчтой зохион байгуулах шаардлагатай. Ер нь өндөр хөгжилтэй улс орнуудын дэлхийд нэр хүндтэй их сургуулиуд том байдаг нь түүний давуу талуудыг ашиглан хөгжих боломж өндөр байдагтай холбоотой. Тэр ч чанараараа том их сургуулиуд нь үлгэрлэн, манлайлж бусад нь тэднээс суралцаж, хөгжих нь менежментийн хөгжлийн хандлага юм.

Зах зээлийн шилжилтийн он жилүүдэд манай оронд санхүүгийн удирдлагын чиглэлээр хийгдсэн эрдэм судлалын ажлууд ерөнхийдөө макро түвшинд болон микро түвшиндээ бизнесийн байгуулагад голлон чиглэж байсан нь аргагүй. Манай төрийн өмчийн их, дээд сургуулиуд нь санхүүгийн удирдлагын өөрийн гэсэн жар гаруй жилийн уламжлалтай бөгөөд тэр нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн сууринд үндэслэгдэж байв.

Их, дээд сургуулиудын санхүүгийн удирдлагын шинэчлэлийн асуудлууд тодорхой эрх зүйн орчны хүрээгээр хязгаарлагдаж ирсэн нь энэ талаарх онол практикийн аль ч түвшинд ойлголт бага байгаатай холбоотой. Энэ чиглэлийн судалгааны ажлыг дэмжиж хөгжүүлэх шаардлагатай бөгөөд их, дээд сургуулиудын санхүүгийн удирдлагын асуудалд арга зүйн талаас хандах нь практикийн чухал ач холбогдолтой байх болно.

Их, дээд сургуулиудын санхүүгийн удирдлагад өөрчлөлт хийх нийгмийн шинжтэй эерэг ба сөрөг олон хүчин зүйл бүрдээд байна.

Боловсролын байгууллагын онцлог, энэ салбарынхны хувьд нэлээд төвөгтэй асуудал бол сургалтын үйл ажиллагааны цикл, санхүүгийн жилтэй зөрдөг, түүний нэгийг нөгөөд нь шилжүүлэх байдлаар зохицуулах гэсэн санаа байдал.

Энэ асуудал эрдэмтэн, судлаачдын анхаарлыг татсаар ирсэн бөгөөд үүнийг нэг тийш болгох ултай үндэслэл олох судалгааг хийж “...зөвхөн түлшиний зардал хэмнэх мэтийн эдийн засгийн талаасаа мөнгөөр хэмжигдэхийн аргагүй их ач холбогдолтой бөгөөд уламжлалт хичээлийн жил нь сургалтын болон эрүүл мэндийн талаасаа монгол хүнд хамгийн сайн зохицсон хуваарь байна.” гэсэн дүгнэлтэд хүрчээ.<sup>5</sup> Үүний дараагаар, Б.Оюунцэцэг “Нягтлан бодох бүртгэлийн хуулинд өөрчлөлт оруулж, дээд боловсролын байгууллагууд хичээлийн жилээр тайлан баланс гаргах хэрэгтэй” гэсэн санааг санхүүгийн дээд байгууллагуудаас анхаарч үзэх шаардлагатай,<sup>6</sup> гэсэн бол Ж.Цэвээндорж “...төсвийг нэмэгдүүлэхээс илүү зардлыг хэмнэх үүднээс, ...манай орны нөхцөлд сургалтыг дулааны улиралд шилжүүлэх, багш нарын цагийн ачаалыг нэмэгдүүлэх, цагийн багшаар хичээл заалгавал зардал хэмнэх боломжтой”<sup>7</sup> гэдгийг санал

<sup>5</sup> Н.Бэгз “Глобалчлалын үеийн Монгол улсын боловсролын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд” УБ, 2001

<sup>6</sup> Б.Оюунцэцэг “Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүгийн бүртгэл, хяналтын тогтолцоог боловсронгуй олгох асуудал”. 2005 он

<sup>7</sup> Ж.Цэвээндорж. “Монгол улсын боловсролын тогтолцоог санхүүгийн удирдлагаар дэмжих зарим асуудал”. 2006

болж байв. Энэ нь боловсролын байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн түвшинг дээшлүүлэх арга зүйг шинэчлэх хэрэгцээ байгааг харуулж байна.

Мэдээллийн технологийн дэвшил, давуу талуудыг ашиглан удирдлагын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн санг бүрдүүлэх боломж нэгэнт бий болоод байна. Түүнийг боловсронгуй болгож, эзэмшихийн зэрэгцээ түгээн дэлгэрүүлэх нь чухал бөгөөд энэ нь хичээлийн болон санхүүгийн жилийг шилжүүлэх тухай дээрх асуудлаас хялбар байх нь ойлгомжтой.

ТБУС хуулийн хүрээнд хийгдэж байгаа шинэчлэл нь төрийн өмчийн их, дээд сургуулиудыг санхүүгийн удирдлагын чиглэлээр дараах шинэчлэлийг хийх шаардлага тавиад байна. Үүнд:

- ◆ жилд нийлүүлэх бүтээгдэхүүн, түүний орлого, санхүүжилтын хэрэгцээгээ бодитой тодорхойлох
- ◆ нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт үндэслэсэн санхүүгийн тайлан бэлдэж гаргах
- ◆ нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн бүртгэлийн бодлогыг тодорхойлох
- ◆ урт болон дунд хугацааны зорилгын агуулгаа шинээр томьёолох, бүтээгдэхүүнд суурилсан төсөв боловсруулах
- ◆ удирдлагын болон санхүүгийн мэдээллийн баазыг бүрдүүлж боловсруулахад мэдээллийн технологийг нэвтрүүлэх
- ◆ дүн шинжилгээ хийх чадавхийг бий болгох, оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлэх, санхүүгийн менежментийн арга барилд суралцах

Төрийн өмчийн их, дээд сургуулиуд хуулийг хэрэгжүүлэх, гол нь сургалтын төлбөр, төсвөө батлуулж төрийн сангаас тодорхой хэмжээний санхүүжилт авахын тулд бүтээгдэхүүнийг тодорхойлох ажлыг ямар нэг байдлаар хийсэн боловч түүнийг төлөвлөх, хяналт-шинжилгээ хийх, тайлагнаад шаардлагатай орчин / зохион байгуулалт, дотоод мэдээллийн, арга зүйн гэх мэт/-г бүрдүүлж хөгжүүлэх асуудлыг орхигдуулаад байгаа юм.

Дээрх шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэх гол нөхцөл нь санхүүгийн удирдлагын мэдээллийн үндэс, суурь болох нягтлан бодох бүртгэлийн шинэчлэл юм. Энэ нь нягтлан бодох бүртгэлийн арга зүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн бүтэц, түүнийг хэрэглэхэд тавигдах шаардлагын үүднээс санхүүгийн тайланда илүү тусгалаа олсон байдаг. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь нэгдсэн стандартай боловч хэрэглэгчдэд төдийлөн ойлгомжгүй байгаа нь салбарын онцлогийг илэрхийлэх дэлгэрэнгүй үзүүлэлтүүдийг тусгалгүй, улсын секторын нэгдсэн тайлангийн түвшинд боловсрогдсон ерөнхий бүтэцтэй маягтыг шууд нөхдөг буруу зуршилтай холбоотой. Тэгэхээр, санхүүгийн тайлангийн хүрээнд түүний тодруулга, нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын бүртгэлийн агуулгыг сайжруулж, шинэчлэх шаардлагатай. Ингэж чадвал эдийн засгийн шинжилгээ, төсвийн төлөвлөлтийн үндэслэл сайжран, бүтээгдэхүүний өртөг тооцох, хянах, удирдлагын шийдвэр гаргах түвшин ч

дээшлэхэд нөлөөлнө. Иймээс энэ шаардлага төрийн өмчийн томоохон их сургуулиудад хэрхэн хангагдаж байгааг санхүүгийн тайлангийн “СТ-2А”–ийн үзүүлэлтүүдийн бүтцээр жишээ болгон үзүүлье.

**Хүснэгт 1**

*Төрийн өмчийн зарим их сургуулиудын  
“Санхүүгийн үр дүнгийн тайлан” СТ-2А үзүүлэлтүүдийн бүтэц*

Дансны Код	Тайлангийн үзүүлэлт	Дэлгэрэнг Үй Үзүүлэл	Тайлан гаргасан үзүүлэлтийн тоо				
			A	B	V	Г	Д
<b>1</b>	<b>I. Үйл ажиллагааны орлогын дүн</b>	<b>42</b>	6	41	5	13	6
1.3	Татаас санхүүжилтийн орлого	<b>8</b>		8	1	8	3
1.4	Тусламжийн орлого	<b>4</b>	1	4	1	1	1
1.5	Бараа, үйлчилгээний орлого	<b>29</b>	4	28	2	4	1
<b>2</b>	<b>II. Үйл ажиллагааны зардлын дүн</b>	<b>60</b>	31	28	31	48	34
2.1	Ажиллагчидтай холбогдсон зардал	<b>20</b>	2	7	2	7	4
2.2	Бараа, үйлчилгээний ургсал зардал	<b>39</b>	28	20	28	39	29
	<b>III. Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>1</b>	1	1	1	1	1
1.5	<b>IV. Үйл ажиллагааны бус орлого</b>	<b>3</b>		3	1	3	1
2.6 2.7	<b>V. Үйл ажиллагааны бус зардал</b>	<b>3</b>	1	3		3	
	<b>VI. Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>1</b>	1	1	1	1	1
	Үзүүлэлтийн нийт тоо	<b>110</b>	41	77	39	69	52
	Шаардлагатай үзүүлэлттэй жишсэн хувь	<b>100</b>	37	70	35	63	47

**Эх сурвалж :** 2008 оны санхүүгийн тайланг үндэслан гаргав.

a/ Дээрх их сургуулиудын санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь ижил биш, хэт хураангуйлсан, адил эх үүсвэрийн орлогыг өөр өөрөөр бүртгэсэн, бүтээгдэхүүнтэй холбоотой байдлаар илэрхийлээгүй, агуулгын ялгаатай, ерөнхийдөө тайланг “боож” гаргасан нь тэдгээрийг харьцуулах, эдийн засгийн шинжилгээ хийх, шийдвэр гаргахад хангалттай мэдээлэл болгон ашиглахад ач холбогдол багатай байгаа нь харагдаж байна. “Б” сургууль үйлчилгээний орлогыг, “Г” сургууль зардлыг арай дэлгэрэнгүй үзүүлэлтээр харуулжээ.

Их сургуулиудын нийт орлогын 70-90 орчим хувь нь зөвхөн сургалтын төлбөрөөс бүрддэг. Иймээс ч сургалтын төлбөртэй холбоотой асуудал

олны анхаарлын төвд байх нь аргагүй. Санхүүгийн тайланг хэрэглэгчдийн хүрээ уlam нэмэгдэж, түүний ил тод байдлыг шаарддаг.

Их сургуулиудын ашиглаж байгаа санхүүгийн программ нь шаардлагатай үзүүлэлтүүдийн мэдээллийн сантай, өөрчлөлт хийх боломжтой тохиолдолд тайланг зохих хэмжээнд гаргахад төвөгтэй биш. Харин тийм боломжгүй бол мэдээллийн системийг шинэчилж, хөгжүүлэх шаардлага тулгарна.

### Хүснэгт 2

*Төрийн өмчийн зарим их сургуулийн үйл ажиллагааны орлогын зарим үзүүлэлт*

Төрийн өмчийн их сургууль Үзүүлэлт		A	B	V	Г	Д	Дүн
Санхүүжилтийн орлогын эх үүсвэр / сая. ₮ /		8880.9	15552.0	7040.8	4469.2	5705.7	41648.6
Санхүүжилтийн орлогын нийт дунд эзлэх хувь	Үндсэн үйл ажиллагааны	87.0	77.4	69.8	73.3	85.9	78.6
	улсын төсвөөс	4.5	7.6	23.5	7.1	5.2	9.6
	өмчлөлтэй холбоотой	0.7	1.0	1.0	0.3	0	0.7
	оюутны байр	0	1.2	0	0	0	0.1
	туслах үйл ажиллагааны	3.3	10.3	5.7	9.0	5.9	6.8
	бусад	4.5	2.5	0	10.4	2.9	4.2
Урьдчилж орсон орлого сая. ₮	Бүгд	2869.2	2729.2	0	0	526.0	6124.4
	Төсвийн ХО		0	0	0	526.0	526.0
		Сургалтын төлбөр	2520.4	0	0	0	2520.4
	Оюутны байрны орлого		208.8	0	0	0	208.8
Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл / сая. ₮ /		1978.2	3412.5	1538.6	863.5	24.7	7817.5


*Эх сурвалж : 2008 оны санхүүгийн тайланг үндэслэн тооцов.*

б/ Мөнгөн хөрөнгийн оны эцсийн үлдэгдэл 7817.5 сая төгрөгийн хичнээн нь ямар эх үүсвэрийн үлдэгдэл болон урьдчилж орсон орлого, хэмнэлт болохыг нарийвчлан тодорхойлохгүй байгаа нь хариуцлагыг бүрхэгдүүлэхийн зэрэгцээ мөнгөн хөрөнгийг оновчтой удирдаж чадахгүйд хүргэж байна. Тухайлбал; “Б” сургуулиас бусад нь оюутны байрны болон урьдчилж орсон орлогыг эх үүсвэрээр нь салгаж тусгаагүй байгаа нь анхаарал татаж байна. Оюутны байрны орлого нь зардлаа нөхөхөд хүрэлцдэггүй, үнэндээ алдагдалтай гардаг боловч ихэвчлэн сургалтын

төлбөрийн орлогоос нөхөгддөг. Иймээс оюутны байрны орлого, зардлыг санхүүгийн тайланд ялгаж тусгадаггүй байна. Энэ нь зөвхөн орлогыг үзүүлэлтүүд (хүснэгт1)-ийн дагуу бүртгээгүйгээс гадна нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт бүрэн шилжээгүй болохыг харуулж байгаа юм. Мөнгөн хөрөнгийг шинжлэхгүй байгаа нь мөнгийг урсгалаар нь зарцуулах, санхүүгийн чадваргүй байдлыг халхлах, нөөцийн чадавхийг хөгжүүлэх боломжийг алдагдуулах зэргээр удирдлагыг санхүүгийн бодлого боловсруулж хэрэгжүүлэх үүргээс нь хөндийрүүлнэ.

График 1.

*Төрийн өмчийн зарим их сургуулийн зарим зардлын нийт дунд эзлэх хувь*



в/ Сургуулийн төсөв нь өмнөх жилүүдийн хүрсэн түвшинг төсвийн хүрээний мэдэгдэлд багтаан сургалтын төлбөрийг инфляцийн хамгийн бага утгаар нэмэгдүүлэхээс хэтрэхгүй байна. Тухайлбал; 2007 онд инфляцийг 8 хувь байна гэж үзээд 2007-2008 оны хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 5хувиар нэмэгдүүлсэн боловч инфляци 14 хувь, 2008 оны эхний хагаст 20 хувь, оны сүүлчээр 34 хувьд тус тус хүрч өссөн. Сүүлийн 5 жилийн дунджаар их сургуулиудын санхүүгийн гүйцэтгэлийн нийт төсөвт зардлын дунд ойролцоогоор 10 хувь нь тогтмол зардал, 66 хувь нь цалин, 24 хувь нь бусад зардлууд эзэлж байна.

Энэ тохиолдолд сургуулиуд оюутны тоо болон сургалтын төлбөрийн хязгаарын түвшинд төсвөө баталж, эн тэргүүнд тогтмол зардал, цалинг тооцоод үлдсэн 24 орчим хувийг хэрхэн хүргэж зарцуулах вэ? гэдгийг л шийдэхэд хүрнэ. Одоогийн байдлаар дээрх сургуулиудын санхүүгийн шинжилгээнд, гүйцэтгэлийг төсөвтэй нь зэрэгцүүлж өөрчлөлтийг хянах хэлбэр зонхилж байна.

Орлого, зардал, өр авлагыг бодитой тооцолгүй, хөрөнгийн талаарх олон мэдээллийг тодруулалгүй орхигдуулж байгаа нь төсвийн төлөвлөлт,

хяналт-шинжилгээ, цаашдын хандлагын талаар үнэлж, тодорхойлох боломжийг алдагдуулснаар тааруухан менежментэд хүргэдэг.

*Төсвийн төлөвлөлт, шинжилгээний үндэслэл*

Төсвийн төлөвлөлт нь хамгийн сайн үр дүнд хүрэхэд шаардлагатай төсвийг бүрдүүлэх, нөөцийг оновчтой хуваарилах, зарцуулах, мөн эрсдэлтэй, зарим бэрхшээлтэй асуудлыг агуулсан, зарлагад хяналт тавих асуудлаас илүү чухалд тооцогдог менежментийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд зорилгоор удирдах хэрэгсэл мөн. Төсвийн төлөвлөлтийн явцад гадаад болон дотоод орчны нөлөөллийн чиг хандлага, хэлбэлзлийн түвшинг шинжилж, таамаглал дэвшигүүлэх буюу орцыг тооцоолдог.

ТБУС-ийн хуулинд заасны дагуу аккруэл суурьтай төлөвлөлтийн зарчим болох бүтээгдэхүүнээр төсөвлөх аргад шилжихэд бэлдэж байна.

Бүтээгдэхүүнээр төсөвлөх аргаар төсөв боловсруулахад хамтад нь эсвэл дангаар нь ашиглаж болох хэд хэдэн аргуудаас Тэг сууриас болон хүрсэн түвшингээс төсөвлөх аргыг сонгож хэрэглэх нь түгээмэл байдаг.

- Тэг сууриас төсөвлөх арга нь төсвийн цикл бүрийг ”0”-ээс эхэлдэг. Өмнөх жилийн төсвийг өртгийн мэдээллийн зорилгод ашигладаг. Зөвхөн нэг удаагийн төсөв боловсруулах үйлдлүүд гэхээсээ илүү удирдлагын үйл ажиллагааг төсвийн харилцан уялдаа бүхий төлөвлөлтийн цогц болгодог. Байгууллагыг бүхэлд нь шинжилж, ажил үйлчилгээний талаар шийдвэр гаргахад чиглүүлнэ.
- Хүрсэн түвшингээс төсөвлөх нь өмнөх жилийн батлагдсан төсвийг суурь болгон авч, нөөцийн хэмжээнд өөрчлөлтүүдийг тусгах замаар түүнийг ирэх жилийн төсөв рүү хөрвүүлэх арга юм. Энэ нь өмнөх жилийн ажил үйлчилгээнд төдийлэн шинжилгээ хийлгүйгээр төсвөө бэлтгэдэг учир төсөв бодитой бус болдог.

Төрийн өмчийн их, дээд сургуулиуд бүтээгдэхүүний төсөвлөлтөд хараахан шилжээгүй бөгөөд хүрсэн түвшингээс төсөвлөх аргыг голчлон хэрэглэдэг. Бүтээгдэхүүнээр төсөвлөх нь бүтээгдэхүүн нийлүүлэлтийн болон санхүүгийн үйл ажиллагааны үр дүнгийн удирдлагын нэгдлийг хангах, гүйцэтгэлийн үр дүнг зэрэгцүүлэн үнэлэх суурь мэдээлэл болно. Иймээс бүх түвшинд хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, нөхцөл байдлыг бодитой үнэлж тусгасан байхыг шаардана.

Их, дээд сургуулиуд шинээр томъёлоод байгаа стратегийн зорилгодоо хүрэхийн тулд хамгийн зөв арга замыг сонгож хэрэгжүүлэх нь чухал. Үүний тулд сургалтын үйл ажиллагааны болон санхүүгийн менежментийн шинэчлэлийг хамтад нь авч үзэх асуудал тулгарч байна.

Сургалтын “кредит систем”-д шилжсэнээр дээд боловсролын агуулгын багтаамжийг “кредит цаг”-аар хэмжих, жишиг, дээд боловсрол олгох, мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг бүтээгдэхүүнээр илэрхийлэн өртөг, зардлаа тооцож, төлөвлөх, хяналт тавих, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх, их, дээд сургуулийн санхүүгийн чадварыг дээшлүүлэх зэрэг олон талт шинэчлэлүүдийг хэрэгжүүлэх боломж бүрдэж байгаа юм.


Кредит системийн монгол загварыг боловсруулан хэрэгжүүлж эхлэхэд манай орны эрдэмтэн судлаачид, их , дээд сургуулиуд манлайллан шинэчлэлийн үйлсэд бодитой хувь нэмэр оруулахыг зорьж, түүнийг өөр өөрийн онцлогт тохируулан хөгжүүлж ирсний дүнд сургалтын ажлын зохион байгуулалт талаасаа нэлээд ойролцоо түвшинд хүрээд байна. Гэхдээ түүнийг илүү уян хатан, бодитой болгох шаардлагатай. Төсвийн төлөвлөлт, бүтээгдэхүүний өртөг тооцох, эдийн засгийн шинжилгээ хийх, хянах зэрэг асуудлууд тус тусдаа арга зүйтэй, тооцооны аргачлалтай байдаг бөгөөд эдгээрийг сургалтын кредит системтэй холбох тал дээр хоцрогдоод байна.

*Бүтээгдэх үүнээр төсөвлөх аргад шилжсихэд зохион байгуулалт, арга зүйн ажлуудыг дараах чиглэлээр гүйцэтгэх ёстой болно. Үүнд:*

1. Анхдагч мэдээлэл нь бодитой, харилцан хамааралтай байх шаардлагатай. Мэдээллийн баазыг бүрдүүлэхэд онцгой анхааран бүртгэл тооцооны (сургалтын болон санхүүгийн) ажилтнуудыг сургах, мэргэжлийн удирдлагаар хангахын тулд мэдээлэл боловсруулах арга зүй, заавар, зөвлөмж, программ хангамжийн асуудлыг шийдэх.
2. Бүтээгдэхүүн (баклавар, магистр, доктор, эрдэм судлал) бүрд тохирсон төсөв, өртөг, гүйцэтгэлийг тооцох нягтлан бodoх бүртгэлийн болон мэдээлэл, хяналт-шинжилгээний тогтолцоо байх шаардлагатай бөгөөд түүнийг бүтээгдэхүүний өртгийн төвүүдээр зохион байгуулна.
3. Төсвийн норм нормативуудыг оновчтой болгох шаардлагатай бөгөөд сургалтын шууд зардлуудыг бүтээгдэхүүнээр дэлгэрэнгүйгээр авч үзэх нь чухал.
4. Оюутны байр, эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажлын орлого, зардлуудыг тус тусад нь ангилж тайланда тусгах,
5. Нягтлан бodoх бүртгэлийн аккурэл суурьт бүрэн шилжиж, зардлыг ангилан, бүтээгдэхүүн бүрээр удирдлагын бүртгэлтэй уялдуулан бүртгэхийн зэрэгшээ, өртөг тооцох, төлөвлөх, эдийн засгийн шинжилгээ судалгааны үндсэн нэгж нь нэг кредитийн үнэлгээ байна. Ингэснээр хичээлийн жил, санхүүгийн жилийн аль алинаар сургалтын төлбөрийн орлого, зардлыг тооцож шинжлэх, тайлагнаж, хянах боломж бүрдэнэ.

Зураг 1

**Их сургуулийн бүтээгдэхүүнээр  
төсөөвлөлтийн харилцан уялдаа**



Судалгааны ажлын үр дүнд бүтээгдэхүүнээр төсөвлөх дараах арга зүйг санал болгож байна. Жишээ болгон 2009 оны төсвийг “Бүтээгдэхүүн 1.1” – ээр төсөвлөх арга зүйн үндсийг авч үзье: ( 2008.07 сард ) боловсруулна.

### I. Анги 1 төсөв. Бүтээгдэхүүн 1.1

а/ Баклаварын дундаж тоо, кредитийн төлөвлөгөө, сонгосон кредитийн гүйцэтгэлийг сургалтын албанаас гаргадаг статистикт үндэслэн тооцно.

2009 оны I-YI сар буюу хаврын улирлын бакл.тоо нь 2008 оны намрын улиралд байсан тоотой адил байна.

Өөрөөр хэлбэл,  $Q_{2009\text{хавар}} \Rightarrow Q_{2008\text{намар}} = Q_1 + Q_2 + Q_3 + Q_4 + Q_5 - Q_{\text{өт}}$

2009 оны IX-XII сар буюу намрын улиралд бакл.тоо

$$Q_{2009\text{намар}} = Q_{2009\text{хавар}} - Q_{\text{хт}} + Q_{\text{элсэлт}}$$

$Q_1, Q_2, Q_3, Q_4, Q_5$  - I, II, III, IV, Y курсын оюутны гүйцэтгэлийн дундаж тоо

$Q_{\text{өт}}$  - өвлийн төгсөлт гүйцэтгэлээр

$Q_{\text{хт}}$  - хаврын төгсөлт төлөвлөсөнөөр

$Q_{\text{элсэлт}}$  - элсэлт төлөвлөсөн тоогоор

$$Q_{\text{бүгд } 2009} = Q_{2009\text{хавар}} + Q_{2009\text{намар}}$$

### б/ Сургалтын төлбөрийн орлого БО

Сургалтын төлбөр өөрчлөлтгүй бол  $BO = Q_{\text{бүгд } 2009} \times P_k_{30}$

$P_k_{30}$  - сургалтын төлбөр жилээр

$P_k$  - нэг кредитийн үнэлгээ (мэргэжил, курсээр)  $P_k = P_k_{30} / 30_{\text{кредит}}$

Сургалтын төлбөр өөрчлөлттэй бол  $P_k_{30} = (P_{k,\text{гүйц}} + P_{k,\text{төл}}) \times 30$

$P_{k,\text{гүйц}}$  - 2008-2009 оны хичээлийн жилийн нэг кредитийн үнэлгээ

$P_{k,\text{төл}}$  - 2009-2010 оны хичээлийн жилийн нэг кредитийн үнэлгээ

$N_{\text{төл}}$  – кредитийн тоо төлөвлөснөөр  $N_{\text{төл, жилээр}} = 30$   $N_{\text{төл, улирал}} = 15$

$$BO = P_{k,\text{гүйц}} \times 15 \times Q_{2009\text{хавар}} + P_{k,\text{төл}} \times 15 \times Q_{2009\text{намар}}$$

Суралцагч мэргэжил, курс болон сонгосон кредитээсээ шалтгаалан ялгаатай төлбөр төлдөг учир дээрх тооцоог кредитээр хийвэл бодитой болно. Тодорхой хэмжээний төлбөрийг урьдчилан төлсөн (урьдчилан төлөгдсөн орлого), эсвэл төлбөр дутуу (авлагаар) байсан ч тэр нь тооцогдоно.

“Анги 1” орлогын эх үүсвэр нь энэ ангийн бүтээгдэхүүн тус бүрээр тооцсон орлогын нийлбэрээр тодорхойлогдоно.

### II. Анги 2 төсөв. “Бүтээгдэхүүн 2.1”

Өмнөх жилд хийгдэж байсан эрдэм судлалын бүтээлийн ажлын 2009 онд үргэлжлэх хугацааны санхүүжүүлэх орлого, тухайн онд шинээр болон оны дундуур дуусах бүтээлийн ажлын санхүүжигдэх орлогын бүтээгдэхүүн тус бүрээр дүнгээр тус тус тооцно

### III. Анги 3, Анги 4, Анги 5 төсөв

Эдгээр ангийн бүтээгдэхүүн нь их сургуулийн дотоод үйл ажиллагаанд чиглэгдэн гадагш нийлүүлэх Анги1, Анги 2 төсөвт багтах тул тодорхой чиглэлээр тусгагдах ёстай зорилт, арга хэмжээ болон хүрсэн түвшинг харгалзан зардлын зүйл ангиар төсөвлөнө. Харин “Бүтээгдэхүүн 2.2” эрдэм шинжилгээний төслийн ажил, “Бүтээгдэхүүн 2.3” захиалгат ажил, “бүтээгдэхүүн 5.3” Оюутны байр, “бүтээгдэхүүн 5.5” цайны газрын

үйлчилгээ зэргийг аж ахуйн тооцоон дээр ажиллах нэгжийн төсвийг туслах үйл ажиллагааны орлого, зарлагад тусад нь тооцно.

#### IV. Сургууль хоорондын тооцоо

Бүрэлдэхүүн сургуулиуд нь мэргэжлийн чиглэлийн дагуу зохион байгуулагдсан. Суралцаач сургалтын төлбөрөө өөрийн үндсэн /эрчим хүч, барилга, геологи гэх мэт/ сургуульдаа төлдөг. Ерөнхий эрдмийн болон зарим мэргэжлийн суурь хичээлүүдийг тухайн чиглэлийн сургуулиуд дээр очиж судлах эсвэл мухайн сургуулийн багш ирж хичээл, сургалтыг явуулна. Энд багшийн цалин хөлс, урамшил, шимтгэл, хөнгөлөлт, хичээл практикийн зардал зэргийг тооцох журмыг боловсруулж мөрдөнө.

Тухайлбал; ерөнхий эрдмийн S.EL 101 Зкр англи хэлний хичээлийг авч үзье. Аль ч сургуульд англи хэлний хичээлийг тодорхой тэнхим эсвэл сургууль хариуцан хөтөлбөрийн дагуу бусад сургууль оюутнуудад үйлчилдэг. Бүрэлдэхүүний ямар сургуулийн хичнээн оюутан, хэдэн кредитийн англи хэлний хичээлийг сонгосоныг сургалтын алба хариуцан гаргана.

S.EL 101	Зкр.	Оюутан *	нэг кр үнэлгээ	Хэлний
боловсролын				
ЭХИС	300	оюутан *3 * 20.4₮ *0.46 = 8445.6₮		сургуульд
БИАС	340	оюутан *3 * 20.5₮ *0.46 = 9618.6₮		= 23454.5₮
ГГТС	210	оюутан *3 * 18.6₮ *0.46 = 5390.3₮		

Үүнээс ерөнхий эрдмийн суурь хичээлийн коэф 0.8, ямар зэрэглэлийн хичнээн багшид хамаарах, кредитийн хичнээн (46) хувиар тооцоо хийхээр журамд тусгасаныг харгалзан 23454.5₮ гадаад хэлний салбарт шилжүүлнэ. Бүх сургуулиуд ийм тооцоог семестр бүр хийж, сургуулиуд суутган тооцооны зөрүүгийн орлогыг үндсэн үйл ажиллагааны санхүүжилтэд, өглөгийг зардалдаа тооцно. Их сургуулийн нэгдсэн дүнгээр энэ тооцоо балансална.

**Ү. Профессор, багшийн сургалтын ажлыг кредитээр тооцож, үнэлэх**  
Сургалтын үйл ажиллагаа нь багшийн хөдөлмөрийн үр дүн байдаг бөгөөд түүнээс үлэмж хамааралтай. Иймд багшийн хөдөлмөрийг сургалтын ажилтай нь уялдуулан, хийснээр өсгөн нэмэгдүүлэх уламжлалт системээр тооцдог.

Жилд гүйцэтгэвэл зохих дээд боловсролын баклаврын, магистрын болон докторын сургалтаас хамааруулан сургалтын ажлын цагийн нормыг үндэслэн цалингийн хэмжээг тогтоож, нормыг давуулан биелүүлсэн цагт нь нэмэлт хөлс олгоно.

a/. Профессор, багш нар нь

сургалтын ажлын зэрэгцээ захиргааны болон эрдэм судлалын ажилд ялгаатай хөдөлмөр зарцуулж байдаг. Иймд тэдгээрийн ажлын хамрах хүрээ, үүрэг, хариуцлагыг нь харгалзан сургалтын ажлын кредитийг дараах байдлаар тогтоов.

**Хүснэгт 3***Профессор, багши нарын сургалтын ажлын ноогдол*

Албан тушаал	Жилийн кредит	
	сургалтын	Эрдэм судлал, бүтээлч ажлын
Профессор	8	8
Дэд профессор	11	5
Ахлах багш	13	3
Багш	15	1
Туслах багш	12-14	

Их сургуулиуд өөрийн онцлогийг харгалзан профессор багшийн сургалтын ажлын болон бусад ажлын кредитийн харьцааг тогтоож журмаар зохицуулна. Профессор, багш нар сургалтын ажлын кредитийг заавал биелүүлж, харин эрдэм судлал, бүтээлч ажлын кредитийг гүйцэд биелүүлээгүй тохиолдолд сургалтын ажлын кредитээр нөхөн биелүүлэх зэргээр сургуулиуд зохицуулж болно. Мөн багшийн ажлын ачаалал, чанарын шаардлагыг харгалзан дээрх ноогдоос давуулан гүйцэтгэх боломжтой сургалтын кредит болон кредитийн үнэлгээг тогтоох нь чухал. Тухайлбал, туслах багш нь дадлагажигч учир илүү цагаар ажиллуулахгүй байх, бусад профессор, багш нар 16 кредитийн 40 хүртэл /хэвийн/ хувийн дотор давуулан гүйцэтгэж нэг кредитийн үнэлгээг тухайн албан тушаалын нэг кредитийн үнэлгээгээр тооцно. Зайлигүй тохиолдолд мэргэжлийн багш түр эзэнгүй, багш хүрэлцээгүй бол 40 хувиас давуулан гүйцэтгэсэн нэг кредитийн үнэлгээг хэвийн үнэлгээнээс арай доогуур тооцно. Энэ нь сургууль хэрэгцээтэй үндсэн багшаар хангдах, багшийн ажлын хэт ачаалал нь тэдний эрүүл мэнд болон сургалтын чанарт сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцлийг бүрдүүлэхтэй холбоотой.

б/ Багшийн ачааллыг нэмэгдүүлэх, цагийн багшаар хичээл заалгах гэсэн зарим (Ж.Ц.) судлаачийн саналыг дараах байдлаар шийдэх боломжтой.

- Хичээлийн хөтөлбөрийн агуулгыг нягtruулах, давхардлыг арилгах замаар нийт кредитийг багасгаж зардлыг хэмнэх
- Лекцийн цаг, бие даалтын цагийн харьцааг авч үзэх
- Лекцийн танхимыг нэгтгэж / 90 оюутан\*2, 90 оюутан\*3 .../ зориулалтын дагуу тусгайлан тоноглох зэргээр шийдэх боломжтой.

в/ Бүтээгдэхүүн тус бүрийн сургалтын ажлыг кредит болгон багцалсан тул хичээлийн агуулгын түвшин, сонгосон оюутны тооноос хамааруулан тооцох арга зүйг томъёогоор илэрхийлбэл: Бүтээгдэхүүн 1.1 баклавар

Тухайн хичээлийн лекц, семинари, лаборатори ба дадлагын хичээл тус бүрт анги дүүргэлт ялгаатай байх тул хичээлийн буюу бүлгийн тоо нь:

$$n_{\text{лекц } i} = \frac{N_i}{k_{\text{лекци}}}$$

$$n_{\text{улир } i} = \frac{N_i}{k_{\text{улир } i}}$$

$$n_{\text{лаб,дад } i} = \frac{N_i}{k_{\text{лаб,дад } i}}$$

k - тогтмол утга буюу анги дүүргэлт ( $k_{\text{лекц } i} \geq 30$ ,  $k_{\text{улир } i} = 35-45$ ,  $k_{\text{лаб,дад } i} = 20-35$ )

N - i-р хичээлийг сонгосон оюутны тоо

n - хичээлийн тоо

Энэ жишээнд  $k < 30$ , хэт бага тохиолдолд хэрхэн тооцохыг сургууль эдийн засгийн (хугарлын цэгийн шинжилгээ) тооцоондоо үндэслэн зохицуулна. Семинарийн хичээлийн анги дүүргэлт нь хамгийн цөөн оюутантай байх боломжит хязгаарын дотор байна. Энэ хязгаараас бага оюутантай бол сургууль санхүүгийн алдагдал хүлээх эсвэл нэг кредитийн үнэлгээг нэмэгдүүлэхэд хүрнэ. Тухайлбал: тусгай орчин шаардлагатай зарим (зураг, дизайн, архитектур г.м) өвөрмөц мэргэжлийн хичээлүүд болон цаашид мэргшүүлэх хичээлүүдийг ч аль болох цөөн оюутантай байлгахад чиглэнэ. Бакалаврын түвшингийн сургалтын ажлын багшийн гүйцэтгэсэн кредит:

$$Ch = \sum_{i=1}^n [(ch_{\text{лекц } i} + ch_{\text{улир } i} + ch_{\text{лаб,дад } i})d_i + ch_{i>30}]$$

**Ch<sub>лекц*i*</sub>** - тухайн хичээлийн лекцээс багшид тооцогдох кредит

**Ch<sub>улир*i*</sub>** - тухайн хичээлийн семинараас багшид тооцогдох кредит

**Ch<sub>лаб,дад*i*</sub>** - тухайн хичээлийн лаборатори ба дадлагаас багшид тооцогдох кредит

**Ch<sub>i>30</sub>** - тухайн хичээлийн 30-аас давсан оюутны бие даалтыг шалгах, шалгалт авах цагт багшид тооцогдох кредит

**d<sub>i</sub>** - хичээлийн агуулгын түвшинд хамааруулан итгэлцүүрийг тогтооно.

- дээд боловсролын мэргэжлийн суурь хичээлүүдэд  $d_i = 0.8$
- мэргэжлийн суурь хичээлүүдэд  $d_i = 1.0$
- мэргшүүлэх хичээлүүдэд  $d_i = 1.2$  гэж тус тус тооцно.

**n** - багшаар тухайн улиралд заалгахаар сургуулиас тогтоосон хичээлийн тоо

Сургалтын төлөвлөгөөнд тусдаа тусгагдсан диплом, төгсөлтийн ажил, курсын төсөл, курсын ажил удирдаж хамгаалуулах зэргээр оюутантай ганцаарчилан ажиллах кредит:

$$Ch_p = 0.06C_p$$

**C<sub>p</sub>** - ганцаарчилан ажиллахад харгалзах кредит

г) Үйлдвэрлэлийн ба хээрийн дадлага, багшлах дадлага удирдсан багшид нэг оюутнаар тооцох кредит:

$$Ch_d = 0.06C_d$$

**C<sub>d</sub>** - тухайн дадалагад харгалзах сургалтын төлөвлөгөөнд заагдсан кредит

д/. Магистр, докторын түвшингийн болон зайн сургалтын ажлын багшийн гүйцэтгэсэн кредитийг оюутны тооноос хамааруулан дээрх томъёог ашиглан

- магистрын түвшний хичээлд  $d_i = 1.5$
- докторын түвшний хичээлд  $d_i = 2.0$  гэж тус тус тооцно.

$N_i=6-15$  байвал магистр  
доктор

$$Ch=[0.68+0.082(N_i-5)]C_i$$

$$Ch=[0.68+0.082(N_i-5)]C_iK_{3/3}$$

$N_i=16-60$  байвал магистр  
доктор

$$Ch=[1.5+0.0125(N_i-15)]C_i$$

$$Ch=[1.5+0.025(N_i-5)]C_iK_{3/3}$$

$N_i$  – i –р хичээлийг сонгосон магистр, доктор оюутны тоо

$C_i$  – i –р хичээлийн кредит

$K_{3/3}$  – багшийн эрдмийн зэргээс хамаарах итгэлцүүр:

Шинжлэх ухааны докторын зэрэгтэй багш  $K_{3/3}=1.2$

Доктор (Ph.D) –ийн зэрэгтэй болон бусад тохиолдолд  $K_{3/3}=1.0$

Цаашид бусад профессор, багш нар байгууллагуудтай хамтран ажиллах, гэрээгээр ажил гүйцэтгэх, төсөл хэрэгжүүлэх, ном, сурх бичиг бүтээх зэрэг ажлыг кредитээр тооцно.

Их сургуулийн нэгдсэн төсөв нь түүний бүрэлдэхүүн сургууль болон нэгжийн бүтээгдэхүүний төсөвлөлт, төсөвлөсөн тайлангаас бүрдэнэ.

### Дүгнэлт

1. Их, дээд сургуулиудын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд юуны өмнө санхүүгийн удирдлагын болон сургалтын үйл ажиллагааны шинэчлэлээс эхлэх нь зүйтэй юм. Үүнд: санхүүгийн албыг нягтлан бодох бүртгэлийн албаар орлуулж байгаа одоогийн практикийг өөрчилж оновчтой зохион байгуулан, үүргийг тодорхойлох, программ хангамжийн түвшинг дээшлүүлэх шаардлагатай.
2. Бодит хэрэгцээгээ оновчтой тодорхойлон, санхүүжилтийн эх үүсвэр, эдийн засгийн байдлаа баталгаажуулах нь боловсролын харилцаанд оролцогчдын үүрэг, хариуцлага, сонирхолд нийцнэ. Санхүүгийн шинжилгээг дотоод үйл ажиллагааны шинжилгээтэй хослон бүрэлдэхүүн сургууль тус бүр дээр хийх нь бүтээгдэхүүнээр төсөвлөх, үр дүнд чиглэсэн дунд хугацааны төсвийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.
3. Бүтээгдэхүүнээр төсөвлөлт, хяналт-шинжилгээнд кредитээр тооцох арга зүйг хүрсэн түвшингээс төсөвлөх, тэг сууриас төсөвлөх аргатай хамтад нь ашиглаж, боловсронгуй болгох тал дээр түлхүү анхаарч, нэгж хэсгүүдийн уялдаа холбоог сайжруулах, сургуулийн үйл ажиллагааг дэмжих нь чухал.
4. Бүтээгдэхүүн төсөвтэй холбогдохын хирээр нягтлан бодох бүртгэлийн ач холбогдол нэмэгдэж, өртгийг тооцох, хяналт, хариуцлагын

тогтолцоо бүрдэж, нөөцийн ашиглалт сайжран, бүтээгдэхүүний тооны өөрчлөлтөөс чанарын өөрчлөлтөд илүү анхаарна.

### **Ашигласан ном зүй**

1. “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль” УБ, 2002
2. Н.Бэгз “Глобалчлалын үеийн Монгол улсын боловсролын хөгжлийн онол арга зүйн үндсэн асуудлууд” УБ, 2001
3. Д.Бадарч, Д.Энхболд, Г.Батхүрэл “Кредит систем” УБ, 2000
4. Д.Дагвадорж, “Макромаркting ба төрийн удирдлага” илтгэл УБ, 2008
5. Ц.Аюурзана “ Компаний санхүү” УБ, 2009
6. “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн аргачлал, заавар” УБ, 2006 он
7. “Мөнгө санхүү” сэтгүүл 2003 № 2, 2007, 2008
8. <http://www.whitehouse.gov/omb/gil/gil-home.html>